



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 04/45

Мандалговь

**“Боловсрол, соёл, урлагийн газрын барилгын
засварын ажлын / Дундговь, Сайнцагаан сум/-ын гүйцэтгэгчийг
сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Боловсрол, соёл, урлагийн газрын барилгын засвар / Дундговь, Сайнцагаан сум/-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Д.Нэргүй (Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын Барилгын хэлтсийн дарга)

Гишүүд: Ё.Дашням (Иргэний төлөөлөл)
С.Алтантогос (3 дугаар цэцэрлэгийн нярав)
Б.Батхүү (Байгаль орчин аялал жуулчлалын газрын
мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Б.Адъяасүрэн (Орон нутгийн өмчийн ХАА хариуцсан
ахлах мэргэжилтэн)

Хоёр. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш ажлын 2 хоногийн дотор хуралдуулж тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Д.Нэргүй)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Адъяасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060176